



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/91

Биндэр сум

Зарим албан хаагчдыг зайнаас
цахимаар ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3, 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэг, "Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2026 оны 119 дүгээр тогтоолын 4 дэх заалт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/86 дугаар тушаалын хавсралтын 3.4, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд долоо хоногийн ажлын нэг өдөр албан хаагчдыг зайнаас цахим сүлжээгээр 2026 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2. Албан хаагчдыг "зайнаас цахим сүлжээгээр ажиллах" хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын цагийн бүртгэл, цаг ашиглалтын байдал, ажлын гүйцэтгэл, үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаяр)-т даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчийн зайнаас цахимаар ажилласан өдрийн хоол, унааны зардлыг хасаж тооцохыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



ХБОН-ХТ-ХТ-ХТ
ХБОН-ХТ-ХТ-ХТ
ХБОН-ХТ-ХТ-ХТ

Биндэр сумын Засаг даргын 2020 оны 06 дугаар
сарын 02-ны өдрийн 02 тоот захирамжийн хавсралт



Зарим албан хаагчдыг зайнаас
цахимаар ажиллуулах хуваарь

№	Албан тушаал	Албан хаагчийн нэр	Зайнаас цахимаар ажиллах гараг				Ажил үүрэг гүйцэтгэх байршил	Нийтлэг аргачлалын 3.4-т заасан нөхцөлийг хангасан эсэх
			I улирал	II улирал	III улирал	IV улирал		
1	Мандалхаан багийн Засаг дарга	Э.Мөнгөншагай		Даваа	Даваа	Даваа	Шаазгай 5-509	Тийм
2	Баянгол багийн Засаг дарга	Ж.Ганзоригт		Баасан	Баасан	Баасан	Худалдаа 3-309 тоот	Тийм
3	Онон багийн Засаг дарга	Б.Тунгалаг		Мягмар	Мягмар	Мягмар	Өлзийт 2-204 тоот	Тийм